Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн арван дөрөвдүгээр хуралдааны тэмдэглэл /2015-12-18/

Үндэсний зөвлөлийн арван дөрөвдүгээр хуралдаан 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 14 цаг 00 минутад Төрийн ордны "В" танхимд эхлэв.

Хуралдаанд Уул уурхайн сайд Р.Жигжид, Уул уурхайн яамны СБТГ-ын дарга Н.Энхбаяр, Уул уурхайн хэлтсийн дарга Д.Дамба, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайхан, Сангийн сайд Б.Болорыг орлож, НББ-ын мэргэжилтэн Г.Зулай, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алгаа, Монголын нүүрс ассоциацийн тэргүүн Л.Даваацэдэв, Монполимет ХХК Группын гүйцэтгэх захирал С.Энхтуяа, Петрочайна дачин тамсаг ХХК-ны мэргэжилтэн Э.Болормаа, Энержи ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Батцэнгэлийг орлож, мэргэжилтэн Б.Сугармаа, Оюутолгой ХХК-ны ерөнхийлөгч Андрью Вүүдлэйг орлож, мэргэжилтэн Х.Лхамаа, ТАН эвслийн зохицуулагч Д.Эрдэнэчимэгийг орлож, Транспарэнси интернэйшнл Монгол байгууллагын ерөнхийлөгч Л.Төр-Од, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Ариун суварга хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын ТУЗ-ын гишүүн Л.Долгормаа, Монголын байгаль эхийн аврал сан ТББ-ийн тэргүүн Н.Наранцэцэг, Хөвсгөл далайн эзэд ТББ-ийн тэргүүн Б.Баярмаа, Ил тод сангийн тэргүүн Д.Цэрэнжав, Монголын Байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд нар оролцов. Хуралдаанд Үндэсний зөвлөлийн 30 гишүүдээс 18 гишүүд оролцож ирц 60 хувьтай байв.

Мөн хуралдаанд Татварын ерөнхий газрын байцаагч Д.Энхтуяа, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн мэргэжилтэн А.Отгонтунгалаг, Мэдээлэл технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Монголын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн арван гуравдугаар хуралдааныг Уул уурхайн сайд Р.Жигжид нээж үг хэлэв.

Р.Жигжид: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдөр бид Монгол улсын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн арван дөрөвдүгээр хуралдааныг хийхээр цуглаад байна.

Тухайн үед ОҮИТБС-ыг хэрэгжүүлж буй 30 гаруй орноос Монгол улс сайн үнэлгээ авч, ОҮИТБС-ын дүрмийн шаардлага хангасан 4 дэх орноор хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд 2011 оны 3 дугаар сард Парис хотноо зохиогдсон ОҮИТБС-ын тавдугаар хурлын үеэр тус санаачилгын Удирдах хорооны даргын нэрэмжит цомоор шагнагдаж байсан билээ.

Санаачилгыг хэрэгжүүлснээр итгэлцэл нэмэгдэж, хариуцлагатай байдал сайжрах тул энэ эрч хүчээ алдалгүй ажиллахыг оролцогч талууд онцгой анхаарч, ололт амжилтаа бататгах шаардлага бидний өмнө зүй ёсоор тавигдаж байна.

Монгол улсын Засгийн газраас геологи, уул уурхайн салбарыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр багагүй ажлыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал, Төрөөс эрдэс баялагийн салбарт 2014-2025 онд баримтлах бодлого, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн

эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулга, Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Ашигт малтмалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, түүнчлэн Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 176 дугаар конвенцид нэгдэн орох зэрэг эрх зүйн баримт бичгийг Улсын Их Хурлаар батлуулаад байна.

Цаашдаа Газрын хэвлийн тухай хуулийг шинэчлэн найруулах, үндэсний геологийн албыг байгуулах, геологийн мэдээллийн санг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг Улсын их хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын их хурлын Эдийн засгийн байнгын хорооны анхдугаар хэлэлцүүлэгт бэлтгэж байна. Дээрх хуулийн төслийг Улсын их хурлын энэ удаагийн чуулганаар эцэслэн шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

ОҮИТБС нь Засгийн газар, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн эрх тэгш хамтын ажиллагааны нэгж чухал хэсэг бөгөөд цаашид үүнийг зарчим болгон нийгэм эдийн засгийн бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэх, олборлох үйлдвэрлэлийн үр өгөөж, хөрөнгө оруулалтыг дээшлүүлэх хэрэгтэй байна. 2016 оны эхээр зохион байгуулагдах ОҮИТБС-ын Баталгаажуулалтад бэлтгэл сайтай оролцож, улсынхаа нэр хүндийг өндөрт өргөн ажиллахыг хүсэж, уриалж байна. Ингээд ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдааныг нээж, үг хэлэх боломж олгосонд талархлаа илэрхийлж, хуралдааны үйл ажиллагаанд амжилт хүсье.

Хуралдааны журам ёсоор хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулав. Гишүүд хэлэлцэх асуудлыг зөвшөөрч, батласнаар хуралдаан эхлэв.

Р.Жигжид: Хуралдааныг үргэлжлүүлэн Уул уурхайн яамны СБТГ-ын дарга Н.Энхбаяр үргэлжлүүлэн удирдан явуулна. Учир нь миний бие Засгийн газар, Улсын Их Хурал яаралтай асуудал танилцуулах болсон тул хүлцэл өчин, чөлөө авахыг хүсэж байна. Хурлын ажиллагаанд амжилт хүсье.

Н.Энхбаяр: Хуралдааны хөтөлбөрийн дагуу нэгдүгээр асуудлыг Кэй Пи Эм Жи ХХК-ны партнер Марк танилцуулна.

1. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монгол Улсын ОҮИТБС-ын 2014 оны тайлан

Эберст Марк: Өнөөдрийн хөтөлбөрт хараат бус хянагч, нэгтгэгчийн хийсэн ажил, шинэ стандарттай яаж холбогдсон, олж илрүүлсэн зүйл, асуудал бэрхшээл юу байсан талаар болон зөвлөмжүүдийг танилцуулна. Энэ жил шинээр хийсэн зүйл бол эхлэлтийн семинар байсан. Хамгийн гол зорилго нь зөвшилцөл байсан, үүн дээр үндэслээд бид эхлэлтийн тайлангаа гаргасан, үүнийг шинэлэг ажил гэж үзэж байгаа. Дараагийн гол асуудал бол бид нэгтгэлд оруулах компанийн сонголтод анхаарсан. Үүнд эрсдэлд суурилсан сонголтын аргачлалыг хэрэглэхээр болсон, сонгох компаниудаа 2 бүлэгт хуваасан. Нэгдүгээрт, нэг бүрчлэн шалгах компани хоёрдугаарт эрсдэлд суурилсан түүвэрчлэх аргуудыг ашигласан. Дараа нь би орон нутгийн тайлагналыг илүү анхаарсан. Эхлэлтийн семинарын үеэр олон талт ажлын хэсгээс орон нутгийн тайлагналд илүү анхаарах хэрэгтэй байна гэсэн санал гаргасан, үүний дагуу орон нутгийн хэмжээнд тусгайлсан материаллаг босго тавиад, урьд нь ордоггүй байсан компаниудыг нэгтгэлд хамруулсан байгаа. Энэ жилээс ОҮИТБС маань цахим тайлангийн системийг хэрэгжүүлж эхэлсэн, үүнд бид цахим тайланд орж байгаа мэдээллүүд нь үнэн зөв, бүрэн бүтэн байна уу, орох ёстой мэдээллүүд

орсон байна уу гэх мэтээр системийн тайлангийн үнэлгээг хийсэн. Түүнчлэн бид мэдээллийн бүрэн бүтэн байдлыг гэрчлэл болон баталгаажуулалт дээр илүү анхаарч ажилласан байгаа. Энэ нь компани төдийгүй засгийн газрын байгууллагуудаас баталгаажуулалтыг авахыг хүссэн байгаа. Үүн дээр үндэслэн хөндлөнгийн аудитаар гаргуулах хязгаарлагдмал баталгааны тайланг авахыг хүссэн, үүгээрээ онцлог гэж бодож байна. Бид материаллаг босгыг эрсдэлд суурилсан аргад үндэслэн хийсэн байгаа. Бүлэг нэгд нь нэг бүрчлэн нэгтгэх компаниуд буюу бүх компаниуд, бүлэг хоёрт түүвэрлэн нэгтгэх буюу эрсдэлд суурилсан аргаад сонгосон компаниуд орсон. Бид дөрвөн босгыг ашиглан нэгтгэлд хамрагдах компаниудаа сонгосон.Тухайлбал улсын хэмжээний орлого 250 саяас дээш орлоготой байвал нэг бүрчлэн нэгтгэх харин харин түүвэрлэн нэгтгэх компанид 100-250 сая төгрөгний босгыг тавьсан. Орон нутгийн хэмжээнд 100 сая төгрөгнөөс дээш орлоготой байвал бүлэг нэг гэж үзээд нэг бүрчлэн нэгтгэлд хамруулсан, харин 30-100 сая төгрөгийн хооронд орлоготой компаниудыг бүлэг хоёр гэж үзээд түүвэрчлэх аргаар нэгтгэлд орох компаниудаа сонгосон. Үүний үр дүнд материаллаг нөхцлийг хангасан, нэгтгэлд хамрагдах улсын хэмжээний 183 компани орон нутгийн хэмжээнд 59 компани тухайн босгыг давсан байсан. Түүвэрчилсэн байдлаар гарсан, орон нутгийн хэмжээнд 44 компаниас 22 компани түүвэрчлэлд орж орон нутгийн хэмжээнд сонгогдсон байгаа, нийтдээ давхардсан тоог хасаад 236 компани 2014 оны нэгтгэлд орсон. (Танилцуулгыг хавсаргав)

Ингээд нэгтгэлийн үр дүнг танилцуулахад анхны тайлангаар Засгийн газрын тайланд 1,92 их наяд төгрөг, компанийн тайланд 1,65 их наяд төгрөг байсан. Тохируулгын дараа Засгийн газрын тайлан 1,58 их наяд, компанийн тайлан 1,57 их наяд болж өөрчлөгдөн, зөрүү нь нилээд багасан зөрүү нь 2,4 тэрбум төгрөг болсон байна. Дээрх зөрүүний ихэнх нь буюу 2,97 их наяд нь нэгтгэлийн мэдээллийн маягтаа ирүүлээгүйгээс үүссэн зөрүү юм. Энэ компаниудаа хасвал нийт 577 сая төгрөгийн зөрүү үүсч байна. Нэгтгэлийн явцад олж илрүүлсэн зүйл нь нэгдүгээрт компани тайлангаа илүү тайлагнасан, хоёрдугаарт төлбөрүүд нь буруу орлогын ангилалд тайлагнасан байсан. Мөн буцаагдсан төлбөрүүд буцаагдаагүй, өөр компанийн өмнөөс хийсэн төлбөр зэргээс зарүү гарах шалтгаан болсон байна. 2014 оны нэгтгэлд сонгогдсон улсын хэмжээний гол орлогын урсгалыг авч үзвэл татварын ерөнхий газар 56 хувиар хамгийн их орлогыг эзэлж байгаа бол дараа нь газрын тосны газар, гаалийн ерөнхий газрууд удаалж байна. Одоо бид нэгтгэлийн явцад гарсан алдаа дутагдал болон зөвлөмжүүдийг талаар танилцуулна. (Танилцуулгыг хавсаргав)

Н.Энхбаяр: Тайлангийн танилцуулгыг хийсэн компанийн төлөөлөлд баярлалаа. Тайлантай холбоотой асуулт байвал гараа өргөөд асууж болно. Асуулт байхгүй бол санал хэлэх гишүүд байна уу?

С.Мэндсайхан: Засгийн газрын тайлангийн залруулгын хэмжээ сүүлийн жилүүдэд ямар хандлагатай байна, Энэ зөрүү нь буурах хандлага байна уу? Лиценз эзэмшиж байгаа аж ахуйн нэгж компани олборлох үйлдвэрлэл явуулаагүй байсан ч гэсэн түүний үйл ажиллагааны бүх орлогыг засгийн газрын байгууллагаас тайлагнасан байна гэж байна. Засгийн газар гэдэгт татварын ерөнхий газар, гаалийн байгууллагаас гарч байгаа мэдээлэл байх, мэдээллээ ялгаж тайлагнах боломж бололцоо байна уу гэдгийг судлаж, анзаарав уу?

Эберст Марк: Бид нар энэ жил 2014 онд нэгтгэл дээр Засгийн газар талаас өндөр байсан, өнгөрсөн жилүүдийг сайн мэдэхгүй байна. Өмнөх жилүүдийн тайлан ОҮИТБС-ын ажлын албаны цахим хуудсанд байгаа учраас түүнээс харах боломжтой.

Бидний анзаарсан зүйл нь Засгийн газрын тайлан гарахаас өмнө ТЕГ юм уу ГЕГ-тай хамтран ажиллаж, энэ компани тухайн жил олборлолт хийгдсэн үгүйг шалгаж байвал нилээд компани хасагдах төлөвтэй юм.

Д.Эрдэнэчимэг: Хязгаарлагдмал баталгаажуулалтын тайлан гэдэг нь юу гэсэн үг вэ?

Эберст Марк: Энэ нь ОУ-ын Стандарт 3000-ыг дагаж мөрдсөн стандарт байгаа. Энэ бүтэн аудитын тайлан гаргахаас арай бага төрлийн тусгайлсан зүйлүүдийг агуулсан тайлан байгаа. Энэ нь нэгдүгээрт тохиролцсон горимын дагуу явагдана эсвэл батлагдсан стандартын дагуу ажлаа хийх боломжтой байдаг. Тохиролцсон горимын дагуу хийдэг нь аудитороос яг энэ зүйлүүдийг хийхийг хүснэ, үүний дагуу аудиторууд хийдэг тайлан юм. Энэ стандарт 3000 нь үүнийг бодвол арай илүү хүчтэй болно гэхдээ бүтэн аудиты тайлан шиг болохгүй, бид ирэх 7 хоногт болох сургалтуудаас дэлгэрэнгүй тайлбарыг өгөх боломжтой.

Х.Лхамаа: Энэ нь 2014 оны нэгтгэл тайлан дээрээ нэмэлт тайлбар өгнө гэсэн үгүү?

Номиндарь: Тийм

Г.Ганбат: Хязгаарлагдмал баталгаажуулалт хийхдээ уул уурхайн компаниудаас ямар нэгэн нэмэлт төлбөр авдаг уу?

Номиндарь: Энэ ажил нь төлбөртэй хийгдэх ёстой бөгөөд энэ нь гол бэрхшээлүүдийн нэг болдог.

Л.Төр-Од: Нэгтгэлийн мэдээллийн маягтуудыг ирүүлээгүй компаниудын мэдэгдэхгүй орлогын хэмжээ, зөрүү нь ямар байсан бэ? Зарим компаниуд мэдээлэл өгөхөөс татгалзаж байсан гэж байна, үүнийг авахын тулд Монголын УУҮА-тай хамтран ажилласан уу, төрийн байгууллагуудаас төлөөллийн захидлыг бүрэн гүйцэд авахын тул Ерөнхий сайдын ажлын албанаас бичиг явуулах зэргээр хандсан уу? 2014 оны нэгтгэлийн тайлангийн зөвлөмжүүдээс ОҮИТБС-ын 2016 оны төлөвлөгөөнд оруулах, Хараат бус хянагч нэгтгэгчийг 1-2 сардаа багтаан томилох нь зүйтэй гэсэн саналтай байна.

Номиндарь: Мэдээллээ ирүүлээгүй компанийн жагсаалтыг хавсралт 7-д харуулсан байгаа. Хамгийн том зөрүүтэй нь Дарханы төмөрлөгийн үйлдвэр байсан, үүнийг аль болохоор багасгасан. Хамгийн ихдээ 200 гаруй сая төгрөгийн зөрүүтэй байгаа. Бид өөрсдөө болон ажлын албатай хамтран ажилласан харин УУҮА-тай ямар нэгэн байдлаар хамтран ажиллаагүй, Засгийн газрын байгууллагуудтай ч бас адил.

Г.Уранцоож: 2013 оны нэгтгэл тайлангийн зөвлөмжүүдээс харахад ихэнх нь хэрэгжээгүй буюу хэсэгчлэн хэрэгжсэн гэсэн байна. Бид тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй бол тайлан гаргаад ач холбогдолгүй юм. Энэ жилийн тайланд 12 зөвлөмж өгсөн байна. Эдгээр зөвлөмж нь өмнө хэрэгжээгүй зөвлөмжтэй холбоотой юу, эсвэл шинэ зөвлөмжүүд үү?

Номиндарь: Зөвлөмжүүд нь урьдынхтайгаа холбогдоод явна. Өмнөх зөвлөмжөөс хэрэгжээгүй зөвлөмж байсан бол энд орсон байгаа.

Г.Чагнаадорж: Энэ 2014 оны тайлан өмнөх тайлангуудаас сайн болсон байна, тайлан гаргасан компанид талархаж байна. 2009 он хүртэл Иргэний нийгмийн байгууллагууд төрийн байгууллагаас мэдээлэл авах хаалттай байсан. Одоо байдал өөрчлөгдөж, ямар мэдээлэл юу хэрэгтэй байгааг мэдэх боломжтой болсон байна. Орон нутагтай 170 гаруй компани гэрээ хийсэн байна. Бусад нь яагаад хийгээгүй юм бол. Мөн Петрочайна дачин тамсаг яагаад орон нутагт гэрээ хийдэггүй юм бол? Гаалийн байгууллагыг жил бүрийн тайланд муу оролцсон, мэдээлэл өгдөггүй гээд байсан энэ жилийн хувьд сайн муу жишээнд ороогүй байна. Үүнээс харахад төрийн байгууллагууд гайгүй ажиллаж байгаа юм байна гэж бодлоо. Ашигт малтмалын газрын мэдээлэл ил тод нээлттэй болж байгаа нь сайшаалтай юм. Хуралд оролцож байгаа хүмүүст амжилт хүсье.

Номиндарь: Бид Байгаль орчны яаманд хүсэлтээ гаргаж, энэ 170 компанийн гэрээг олж авсан. Тухайн гэрээ байгуулсан компанийн жагсаалтад Петрочайна компанийн нэр байхгүй бол Ашигт малтмалын газар юм уу Газрын тосны газраас мэдээлэл нь ирээгүй байна гэсэн үг юм.

Д.Эрдэнэчимэг: Ажлын хэсгийн хуралдаан дээр тайлангийн орчуулгыг дахин харах хэрэгтэй гэж байсан, одоо сайжирсан байна. Мөн тайланд орж байгаа мэдээллээ эргэж сайн харахгүй бол болмооргүй байна. Тухайлбал, хавсралт 23-т тайлбаргүй хувь хэмжээ тавьсан байсан. Үүнийг засвар оруулаад нийт дансанд эзлэх хувь гэсэн байна. Энэ нь бидний хувьд ач холбогдолгүй юм. Харин өнгөрсөн жилүүдэд тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгө түүний зарцуулалтыг харуулдаг байсан, энэ нь илүү ач холбогдолтой юм. Гэхдээ ажлын даалгавартаа яаж орсон юм бол, ажлын даалгаврын дагуу хийж байгаа болов уу? Мөн орон нутагтай хийсэн гэрээнүүд, тусгай зөвшөөрлийн жагсаалтууд олон хуудас мэдээлэл эзэлж байна, үүний оронд орон нутагтай байгуулсан гэрээний мэдээллийг илүү нарийвчилж оруулсан нь дээр байх.

Н.Энхбаяр: Асуулт дууссан бол санал хэлэх хүн байвал хэлж болно.

Н.Алгаа: Кэй Пи Эм Жи ХХК-нь олон улсын стандартын дагуу хийсэн байна. Цаашдаа шалгаруулалтыг 2 жилээр явуулвал илүү үр дүнтэй байх юм. Нэгдүгээрт гаргасан зөвлөмжөө олон нийтэд таниулж, нотлож сургалт явуулахад хэрэгтэй. 2 жилийн хугацаагаар, жилийн өмнө шалгаруулаад, тайлан гаргах үеэр нь аудитын компанийг хамтад оруулах нь чухал юм. Ажлын хэсгийнхэн нэр томъёон дээр сайн ажиллаад, түүнийгээ эхлэлтийн тайлан дээрээ тусгаж, эртхэн нэгтгэгч байгууллагаа шалгаруулаад ажиллавал үр дүнд хүрэх байх гэсэн саналтай байна.

Н.Баярсайхан: Ажлын хэсгийн хуралдаанаар орон нутгийн хөгжлийн асуудалтай холбоотой гэрээгээ оруулаад бусдыг нь дата бааздаа байлгая гэж тохирсон гэж ойлгосон. Ажлын хэсэг шийдвэл бид тайлангаас авч болно гэж аудитын компани хэлж байна. Энэ шийдвэр гараагүй юм уу?

Н.Энхбаяр: Өмнөх гарсан шийдвэрт тусгагдсан эсэхийг дахин нягталж үзье.

Б.Баярмаа: 2014 оны тайлангаа гаргаад, хэлэлцэж байгаад талархаж байна. Бид гэрээг ил тод байлгах зорилготой ажиллаж байгаа, гэхдээ энэ нь ил тод болж байна уу, ахиц байна уу гэдгийг аудитын компаниар үнэлүүлэх саналтай байна. Ажлын даалгаварт орсон болов уу? Шинэ стандартаар эрхзүйн орчинг үнэлнэ гэж байгаа үүнийг бид дараагийн тайландаа хийх үү? Хуулиуд нь гэрээ, лиценз олгох үйл явцыг ил болгох нөхцлийг хангаж өгч байна уу, үгүй юу гэдгийг үнэлээд зөвлөмж

гаргаад явбал дараа нь оролцогч талууд ажиллахад хэрэгтэй юм уу гэж бодож байна. Өнөөдөр хууль ил болгоогүй учраас компаниуд дутуу мэдээлэл өгч байна. Ирж байгаа мэдээллүүдийг баталгаатай эсэхийг мэдэхгүй, ирсэн нь энэ гэдэг байдлаар аудит ажиллаж болохгүй байх. Төрийн өгсөн мэдээлэл ч үнэн зөв эсэхэд баталгаа байхгүй байна. Дараа жилдээ аудитын ажлын даалгавартаа энэ талаар оруулж ажилламаар байна.

Номиндарь: Бид гэрээт ажлаа тохиролцсон горим буюу холбогдох үйлчилгээний олон улсын стандарт 4004-ыг дагаж хийх ёстой. Үүнд, бид ямар нэгэн төрлийн үнэлэмж өгөхгүй, байгаа юмыг байгаагаар нь харуулах ёстой. Тайлбар тавихгүй, үнэлгээ судалгаа хийхгүй. Харин ажлын даалгавартаа тусгавал болох байх.

С.Энхтуяа: Энэ хийж байгаа тайлангийн чанар нэг нэг жилээр гэрээлэн хийлгэж байгаатай холбоотой байх. Өөрөөр хэлбэл 2-3 жилээр дараалан өгвөл зүгээр болов уу. Үүнийгээ хууль журмандаа тусгаад, ажлын даалгавартаа үнэлэлт дүгнэлт өгөх, ололт амжилтыг харьцуулах тодорхой үзүүлэлтийг гаргах хэрэгтэй байна.

Д.Эрдэнэчимэг: Урьдчилсан баталгаажуулалтаар төрийн өмчит компаниудын талаарх мэдээлэл дээр муу дүн авсан, өмнө нь ч тийм байсан. Энэ нь тайлангийн зөвлөмжид орсон байна. Манай тайлангийн маягтад төрийн өмчит компаниудад зориулсан тусгай маягт байхгүй байна гэтэл хувийн хэвшлийн компаниуд илүү тодорхой мэдээллийг авах шаардлагыг тавьж байгаа. Анхнаасаа маягтад оруулаагүй учраас байгаа маягтаар мэдээллээ өгч байна, дараа нь нэмэлт мэдээлэл авахад хэцүү байгаа нь харагдаж байна. Иймээс маягтаа шинэчилвэл яасан юм бэ?

Г.Чагнаадорж: Газрын төлбөр, усны төлбөр төлсөн мэдээлэл тайланд орсон байдаг. Үүнийг бүр нарийвчилан, ямар хэмжээний газар эсвэл нэг тонн алт угаахад хэдэн литр ус ашигласан байна, түүний төлбөр нь хэд болсон байна гэдгийг харуулах хэрэгтэй, үүнийг мэдэх ёстой ард түмэнд хүргэх хэрэгтэй гэсэн саналтай байна.

Н.Энхбаяр: 2014 оны нэгтгэл тайлангийн асуудалтай холбоотой шийдвэрийн төсөлд санал хэлэх хүн байна уу?

Н.Баярсайхан: шийдвэрийн төслийн дэмжиж байна. Гэхдээ бусад хүмүүсээс гаргасан саналыг тусгаж оруулах саналтай байна.

Д.Эрдэнэчимэг: Энэхүү тайланг Улсын их хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулах гэж оруулсан байсан энэ шийдвэрт бас оруулах саналтай байна.

Н.Энхбаяр: Эхний хэлэлцэх асуудал үүгээр өндөрлөж байна. Мэдээлэл хийсэн компаны төлөөлөлд баярлалаа.

Гарсан шийдвэрүүд:

1. Монгол, Франц улсуудын Кей Пи Эм Жи ХХК-ийн хамтарсан консерцумын боловсруулсан Монгол Улсын ОҮИТБС- н 2014 оны буюу есдүгээр тайланг дэмжиж, хуралдаан дээр гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов.
2. Энэхүү Энэхүү тайланг Монгол Улсын ОҮИТБС-ын ажлын алба болон оролцогч бүх талууд өөрсдийн цахим хуудаст байрлуулах, тайлангийн хураангуй хувилбарыг нийтэд ил тод болгож, сурталчлах нь зүйтэй гэж үзэв.

3. Энэхүү тайлан, 2015 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2016 оны ажлын төлөвлөгөөтэй хамт ОҮИТБС-ын олон улсын удирдах хороонд 2015 оны 12 дугаар сарын 31- ний дотор илгээхийг Ажлын албанд даалгав.
4. Энэхүү тайлан, Үндэсний зөвлөлийн хуралдааны талаар ОҮИТБС-ын Ажлын албатай хамтран нийтэд мэдээлж ажиллахыг Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанд даалгав.
5. Энэхүү тайлангаар заасан зөвлөмж бүрээр:
   5.1 Төлбөрийн тайлагналд ашигласан мэдээлэл технологийн платформ, холбогдох мэдээлэл технологийн хяналтууд болон түүний орчныг сайжруулах чиглэлээр цахим тайлагналын 2 дугаар шатанд шалгалт явуулж, үр дүнг танилцуулахыг Ажлын албанд даалгав
   5.2 Цахим тайлангийн систем ашиглан, электрон хэлбэрээр цуглуулах үндсэн мэдээллийн хэлбэр, цар хүрээг тодорхойлох, маягтын загварыг гаргахад Хараат бус хянан нэгтгэгчийг оролцуулахыг Ажлын албанд даалгав.
   5.3 Тайлангийн мэдээлэл ирүүлээгүй 7 компанийн нэрийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил болгохыг Ажлын албанд даалгав
   5.4 Олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагааны орлогыг бусад үйл ажиллагаанаас ялгах, ангилах судалгааны үүрэг бүхий дэд хэсгийн ажлыг үргэлжүүлэх, үр дүнг Ажлын хэсэгт танилцуулахыг Ажлын албанд даалгав.
   5.5 Төслийн түвшиний ил тод байдлын хүрээнд 5,4-т заасан дэд хэсгийн ажлын даалгаварт оруулж, хяналт тавьж үр дүнг Ажлын хэсэгт танилцуулахыг Ажлын албанд даалгав.
   5.6 Компаниудтай холбоо барих лавлагааг 2015 оны цахим тайлагналын хүрээнд шинэчлэхийг Ажлын албанд даалгав.
   5.7 Тайлагналын зааварчилгааг видео, цаасан хэлбэрт оруулан шинэчлэхийг Ажлын албанд даалгав.
   5.8 Компаниудаас тайлагнасан санхүүгийн мэдээлэл болон үндсэн мэдээлэлд хягаарлагдмал баталгаажуулалт шаардлагтайг компаниудад зааварчилгааг 2015 оны цахим тайлагналын хүрээнд хэрэгжүүлэхийг Ажлын албанд даалгав.
   5.9 Төрийн бүх шатны байгууллагуудаас тайлагнасан мэдээллийн баталгаажуулалтыг Үндэсний Аудитын газартай хамтран шийдвэрлэхийг Ажлын албанд даалгав.
   5.10 Төрийн өмчийн ААН-д сургалт зохион байгуулж, тусад нь гарын авлага боловсруулахыг Ажлын албанд даалгав.
   5.11 ОҮИТБС-ын стандартын дагуу кадастраас шаардсан мэдээллийг цахим тайлагналын 2 дугаар шатны хүрээнд шийдвэрлэхийг Ашиг малтмалын газарт даалгав.
   5.12 Хараат бус хянан нэгтгэгчийг аль болгох эрт сонгон шалгаруулах, ажлыг эртлэн хийлгэхийг Ажлын албанд даалгав.

2. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монгол Улсын ОҮИТБС-ын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тухай

Ш.Цолмон: ОҮИТБС-ын 2015 оны үйл ажиллагааны тайланг урьчилан тараасан байгаа. ОҮИТБС-ын шинэ стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд, одоогийн хууль эрх зүйн орчин, ил байгаа мэдээллүүд, олон улсын зөвлөмжүүдийн дагуу салбарын үндсэн мэдээллийг цуглуулах, боловсруулах ажлуудыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулж, нэгдсэн сан бий болгож, цахим хуудсад байршуулсан, ОУ-ын НБДнГ-ын, ГОУХАН-тэй хамтран шинэ стандартын дагуу баталгаажуулалтад

бэлтгэх болон өөрийн үнэлгээний ажлыг зохион байгуулж, нэмэлт ажлын төлөвлөгөө гарган Ерөнхий сайдаар батлуулж, ажилласны дүнд туршилтын баталгаажуулалтыг зохион байгуулсан байна. Монгол Улсын ОҮИТБС-ын 2013 оны нэгдсэн тайланг сурталчилах ажлын хүрээнд, 2013 оны нэгдсэн тайлангийн дагуу 5 дэд хэсэг гарган ажиллуулж, эхний үр дүнг Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт танилцуулсны дагуу, гэрээнүүд цуглуулах ажлыг зохион байгуулж, гэрээний ил тод байдлын цахим хуудас боловсруулж байна.

Орон нутгийн түвшинд чадавхи бэхжүүлэх хүрээнд Монголиан Майнинг журнал, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран орон нутгийн сүлжээ төслийг хэрэгжүүлж, 16 аймгийн 52 сэтгүүлчийг сургаж бэлтгэсэн, Хойд, баруун, өмнөд бүсийн чуулган, Төв аймаг болон гурван сумын өдөрлөг зохион байгуулж 280 гаруй оролцогч оролцсон байна.

Олон улсын баталгаажуулалтыг 2016 оны 1 дүгээр сард зохион байгуулахаар ОУ-ын удирдах зөвлөл шийдсэн байна. Туршилтын баталгаажуулалтыг 11 дүгээр сард зохион байгуулсан. Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулийн төслийг УИХ хэлэлцэх эсэхээ шийдэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг Эдийн засгийн байнгын хороон дээр байгуулаад ажиллаж байна. /Танилцуулгыг хавсаргав/

Н.Энхбаяр: Танилцуулгатай холбоотой асуулт байвал асууж болно.

Б.Батболд: Мэдээлэлээс харахад зуу гаруй сая төгрөг зарцуулаагүй байгаа юм байна, Дэлхийн банкнаас авах бүх мөнгө дансанд орж ирсэн гэсэн үг үү? Энэ үлдэгдлийг одоо яах вэ? Сургалт хийчиж болоогүй юм уу?

Ш.Цолмон: Дэлхийн банкнаас санхүүжилт бүрэн орсон, боломжийн хэмжээгээр зарцуулаад хэрвээ мөнгө үлдвэл журмын дагуу буцааж шилжүүлнэ.

Д.Эрдэнэчимэг: Зарцуулаагүй үлдэгдлээс болоод дараагийн санхүүжилт танагдах хандлага байдаг, иймээс сургалт суртчилгааны ажлыг ИНБ-уудад даалгаад хийлгэвэл хийх чадавхи байгаа. Дараа жилийн ажлын төлөвлөгөөнд анхаарах хэрэгтэй байна. Мөн Үндэсний чуулган зохион байгуулахад ННФ санхүүгийн дэмжлэг үзүүлсэн, үүнийг тайланд дурдуулмаар байна.

Г.Чагнаадорж: 2014 оны тайланг олон хувь хэвлүүлээд бүх аймаг сумдын дэд зөвлөлд тараах санал байна.

Ш.Цолмон: Бид аль болох мөнгө үлдээхгүй байх талаар ажиллаж байна. Нилээд их юм хэвлүүлнэ, 2016 оны 2 дугаар сард Перуд болох хурлын үеэр үзэсгэлэн гаргах материал гэх мэт.

Б.Баярмаа: Тайланг харахад энэ их ажлыг ажлын алба дангаараа хийж чадахгүй байна. Ажлаа мэддэг чадавхитай хүмүүст ажлаа өгмөөр байна. Бидний гаргасан санал зөвлөмж ажил хэрэг болохгүй байна.

Ш.Цолмон: 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд ажлын хэсгийн хурлаар гаргасан саналуудыг тусгасан байгаа.

Н.Энхбаяр: Энэ нь Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл юм байна. Гадаадын зээл тусламжийн хөрөнгө нь төсвийн нэг бүрэлдхүүн гэж үздэг. Санхүүгийн болон худалдан авах ажиллагаа нь Дэлхийн банкны болон бусад хууль

журмын дагуу явагдах ёстой. Өнөөдөр, он дуусаж байхад санхүүтэй холбоотой ямар нэгэн шийдвэр гарах боломжгүй нь ажиглагдаж байна.

Б.Дэлгэрмаа: Тодорхой шалтгааны улмаас энэ төслийн мөнгөнөөс үлдэх магадлал байгаа. Үүнд, 2016 оны 2 сард болох Перүгийн хуралд оролцох хүмүүсийн зардал 30,000 ам долларыг энэ төслөөс зарцуулах боломжгүй гэдэг шийдвэрийг Дэлхийн банк өгсөн. Мөн дэд зөвлөлийн сургалт хийхээр төлөвлөсөн байсан ч Үндэсний форум хийсэн учраас тодорхой шийдвэр гаргаж байж хийхээр болсон учир энэ зардал хэмнэгдэж байгаа. Үүнийг бид зар сурталчилгааны ажил, хэвлэлийн ажилд зарцуулахаар гэрээлж байгаа. 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд зарим ажлуудыг ИНБ-уудаар хийлгэхээр тусгаж батлуулсан учраас үүнийг хийх боломжтой.

Ц.Даваацэдэв: Тайланд гарсан дүгнэлтээр компаниуд муу оролцож байна гэж байна. Энэ нь хууль эрх зүйн орчинтой холбоотой юм. Манай компаниуд хуулиа барьж ажиллаж байгаа, өнөөдрийн бидний хийж байгаа зүйл тодорхой эрх зүйн хуулиар тогтоосон үндэслэлгүйгээр явж байгаа учраас ингэж харагдаж байна. Хуулиар зохицуулагдаагүй мэдээ тайланг зарим нь өгөөд зарим нь өгөхгүй байгаа юм. Иймээс ирэх оны төлөвлөгөөнд хуулиудын хоорондын уялдааг сайжруулах, ажиллах хүмүүсийн зардал хөрөнгө мөнгийг төлөвлөж ажиллах нь зүйтэй. Өнөөдөр энд болж байгаа мэдээлэлийг Уул уурхайн ассоциаци, Нүүрс ассоциаци болон алт үйлдвэрлэгчдийн холбоодоор дамжуулан хүргүүлэх нь илүү хурдан, үр дүнтэй байна. Харин үүнийг дамжуулах хүмүүсээ чадавхижуулах хэрэгтэй юм. Ирэх 2016 онд үйлдвэрлэгчдийг дэмжсэн ТББ-уудын чадавхийг сайжруулахад анхаарч ажиллахыг хүсье.

Н.Баярсайхан: Сүүлийн жилүүдийн тайлан гаргалтыг харахад тайлан гаргасан компаниудын тоо буурсан мэт харагдаж байгаа. Энэ нь цахимаар тайлан авах болсонтой холбоотой байх. Жижиг аж ахуйн нэгжүүд цахим тайланг гаргах талаар мэдлэг дутмаг, чадавхигүй байгаагаас тайлангаа гаргаж явуулаагүй болов уу. Санаачилгыг хэрэгжүүлэхэд Уул уурхайн ассациаци төдийгүй бусад мэргэжлийн холбоодыг татан оруулах шаардлага байгаа.

Н.Алгаа: Бид уул уурхайн компаниудын төлөөллийг сайн дурын үндсэн дээр томилож ажлын хэсэг , Үндэсний зөвлөлд оруулдаг. Одоо болох чуулганаар илүү идэвхтэй компанийг төлөөллөөр сонгож, томилон сайн ажиллуулах болно.

Л.Төр-Од: ОҮИТБС-ын шинэ стандартыг бүрэн хэрэгжүүлэх ажил чухал байх үүнийг төлөвлөгөөнд дэлгэрэнгүй оруулах боломжтой юу? Энэ ажлын хүрээнд байгалийн баялагийн засаглалын хүрээлэн хамтарч ажиллаж байгаа. Байгалийн баялагийн засаглалын хүрээлэн санаачилгыг хэрэгжүүлэхэд ажлын албанд тодорхой төсөв, хөрөнгийг гаргахаар шийдвэрлэсэн байгаа. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтраад Их 7-н түншлэлд Монгол улс идэвхтэй оролцож байгаа. Бид үүнд оролцож, өөрсдийн туршлагыг бусад улс орнуудтай хуваалцах, эргээд тэднээс туслалцаа авах зэргээр хамтран ажиллаж байгаа. Энэ ажил ирэх онд хийгдэхээр шийдвэрлэгдсэн, үүнийг төлөвлөгөөнд оруулах нь зүйтэй байх. Түүнчлэн бид "Уул уурхай ба авилга" гэсэн судалгааны ажил зарласан. НҮБ-ын бүсийн төвөөс 3 жилийн хугацаатай хөтөлбөр хэрэгжүүлэх болсон үүнд ажлын алба хамтран ажиллах боломжтой юм.

Н.Баярсайхан: Энэ ажлын албаны тайлан юм уу, Дэлхийн банкны гэрээт ажлын санхүүгийн зарцуулалтын тайлан юм уу?

Ш.Цолмон: Энэ нь ажлын албаны тайлан байгаа. Иймд бусад талуудаас нэмж оруулах зүйл байвал оруулж, илүү дэлгэрэнгүй тайлан гаргаж болно.

Н.Баярсайхан: Анхнаасаа тайлангаа дэлгэрэнгүй байдлаар хийсэн бол Дэлхийн банк ч оролцогч талуудын хийсэн ажилтай танилцаж, цаашдаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх, төсөв хөрөнгөө нэмэх талаар хувилбар гарахад нөлөөлж болох байсан байна. Одоо төлөвлөгөөний тайланд нэмэлт оруулвал хэзээ өгөх боломжтой вэ?

Ш.Цолмон: Ирэх 4 дэхь өдрөөс өмнө өгвөл болно.

Б.Дэлгэрмаа: Энэ тайлан нь төлөвлөгөөний дагуу хийгдсэн тайлан юм. Үүнд дахин нэмэлт оруулвал хоорондоо уялдаагүй болох байх. Харин дараа жилийн тайланд бүх оролцогч талууд болон санхүүжүүлэгч байгууллагуудаа тусгаж, оруулах боломжтой.

Н.Баярсайхан: Тэгвэл энэ тайлан хэвээрээ байг. Харин ОУНБД нарын газарт явуулах тайландаа дэлгэрэнгүй оруулахаар тохиролцоё.

Н.Энхбаяр: Асуулт, санал хэлэх хүн байхгүй бол дараагийн асуудалдаа оръё.

Гарсан шийдвэр:

Монголын ОҮИТБС- ын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг гишүүдийн 90 хувь дэмжиж “хангалттай” гэж үзэв.

3. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монгол Улсын ОҮИТБС-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн тухай

Ш.Цолмон: Та бүхэнд 2016 оны ажлын төлөвлөгөөний төслийг урьдчилан танилцуулсан байгаа. Бид 2016 оны Дэд зөвлөлийг чадавхижуулах жил болгох, үйл ажиллагааны төлөвлөгөөг дөрвөн зорилтын хүрээнд бэлтгэсэн. Үүнд, нэгдүгээрт, ОҮИТБС-ын нэгтгэл тайлан болон цахим тайлангийн систем нь олборлох салбар (уул уурхай, газрын тос, уран)-ын эдийн засаг, нийгэмд оруулж буй хувь нэмрийн талаарх бодит, цогц мэдээллийг нэг дор авахуйц найдвартай эх сурвалж болно. Хоёрдугаарт, олборлох салбарт тусгай зөвшөөрөл олгохоос эхлээд орлогыг удирдан зарцуулах хүртэлх бүх үйл явцад ОҮИТБС-ын тайлан дахь мэдээлэл нь ашиглагддаг, хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулдаг болно. Гуравдугаарт, ОҮИТБС-ыг түгээн сурталчлах, талуудын бодитой оролцоог бий болгох мэдлэг ур чадварыг бий болгох нөлөөллийн ажил, ОҮИТБС-ын үйл явцад оролцогч талуудын мэдлэг, ойлголт, чадавхийг бэхжүүлэх, харилцан ойлголцол, хамтын ажиллагааг, итгэлцлийг бэхжүүлнэ. Дөрөвдүгээрт, ОҮИТБС-ын хэрэгжилтийн тогтвортой үйл ажиллагааг хангаж, санхүүгийн бодит дэмжлэгийг бий болгоно. Түүнчлэн санаачилгыг хэрэгжүүлэхэд тодорхой бэрхшээлүүд тулгарсаар байна. Төлөвлөгөөний төсөлд саналаа өгнө үү. (дэлгэрэнгүй төлөвлөгөөг хавсаргав)

Н.Долгормаа: Өнгөрсөн ажлын хэсгийн хурлаар 2016 оны төлөвлөгөөнд хэдэн асуудалд амаар болон бичгээр саналаа өгсөн байгаа. Бид хуулийн асуудалд анхаарах хэрэгтэй байна. Хууль батлагдчихвал компаниуд тайлангаа тогтмол өгнө, ажлын хэсэг ч тогтвортой ажиллах нөхцөл бүрдэнэ. Энэ онд хууль батлуулах талаар тодорхой арга хэмжээ авч, компанит ажил зохион байгуулмаар байна. Бид

төлөвлөгөөний уриандаа хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ, дэд бүтцээ чадавхижуулна гэж оруулмаар байна. Хоёрдугаарт, 2016 онд гаргаж байгаа тайлангаа нарийвчлан авч үзмээр байна. Монгол улсад тохирсон өвөрмөц агуулгатай, ойлгомжтой, цомхон, хэн хүн аваад уншчихмаар болгомоор байна. Гуравдугаарт, найман жилийн тайланд анализ хийх саналтай байна.

Н.Алгаа: Төлөвлөгөөтэй холбоотой асуулт, саналаа тавьмаар байна. Цаг хугацаа их зарцуулж байна.

Б.Дэлгэрмаа: Хууль эрхзүйтэй холбоотой санал байсан. Төлөвлөгөөнд үүнтэй холбоотой 4 төрлийн ажил орсон байгаа. Дараагийн асуудал нь, ОҮИТБС-ын найман жилийн тайланд анализ хийх талаар санал өгсөн. Бид үүнийг жил бүр гаргадаг брошурт тайлангийн зөрүүний талаар өсөлт бууралт зэргийг тодорхой харуулж байгаа.

Л.Долгормаа: За баярлалаа, ойлголоо

Н.Алгаа: Би ажлын албанд талархал илэрхийлмээр байна. Төлөвлөгөөнд ОҮИТБС-ын 2015 оны тайлангийн ирц 85-аас доошгүй хувьд хүрсэн байна гэдэг нь биелэгдэхгүй тоо байж магадгүй, зарим аж ахуйн нэгжүүд 3-4 жил үйл ажиллагаа явуулаагүй байна. Тайлангийн "үнэн зөв" гэдгийг арай өөр үгээр оруулах, үр дүн гуравт, ОҮИТБС-ын цахим тайлангийн системийг боловсронгуй болгоход анхаарах нь чухал, тайлангийн маягтуудаа тодорхой болгох хэрэгтэй.

Б.Дэлгэрмаа: Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 85 хувь гэсэн үг.

Г.Уранцоож: Үр дүн 4-т Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороонд танилцуулна гэж тусад нь оруулмаар байна, боломжгүй гэвэл ТАН эвсэлд даалгачих, бид хийчих боломжтой байх. Хоёрдугаарт, уул уурхайгаас оруулж байгаа орлогын бараг 80-90 хувийг 12 компани оруулдаг гэсэн. ОҮИТБС-ын тайланг хөгжлийн бодлоготой уялдуулмаар байна. Тайлангийн ач холбогдол нь бодлогод нөлөөлж байх ёстой гэж боддог. Үнэхээр хэдхэн компани төсвийн орлогын ихэнхийг бүрдүүлээд байгаа юм бол тэр олон компанид тусгай зөвшөөрөл олгох шаардлага байна уу? Нөхөн сэргээлтээ хийж чадахгүй, байгаль орчинд өчнөөн хор хохирол учруулж байдаг. Тэгэхээр бодлого боловсруулж байгаа хүмүүс маань хөгжлийн бодлоготой уялдуулж бодлогоо боловсруулдаг баймаар байна. Иймээс тайлангийн нийгэм эдийн засгийн үүднээс үнэлсэн үнэлгээ хийлгэх боломж байна уу? Тэгвэл тайлангийн ач холбогдол гарах юм.

Н.Баярсайхан: 2016 оны төлөвлөгөөний төсөлд Дэд зөвлөлийг чадавхижуулах жил болгох санал оруулсан, уриа маягаар тусгагдсан байна. Үүнийг тодорхой бүлэг болгож оруулах саналтай байна. Дэд зөвлөлд чиглэсэн ажлууд өөр өөр бүлэгт салангид байгаа учраас үүнийг нэгтгээд *Дэд зөвлөлийг чадавхижуулах зорилт* гэсэн нэг бүлэг болгох санал байна. Үр дүн 2-т нэгтгэлийн тайланг аймаг аймгаар гаргах гэж 2.11 дээр оруулах, 4.1-ийг хоёр хуваагаад оруулах, 5.1-ийг хоёр салгах, 5.3-т судалгаа хийх гэсэн байна, үүнийг энэ жил шаардлагагүй байх. Ажлын албаны өдөр тутмын хийх ажлыг төлөвлөгөөнд оруулах шаардлагагүй байх, тухайлбал 8.1-р ажил төлөвлөгөөнд байх шаардлагатай юу? Түүнчлэн 10.4.1-р ажлыг мэдээллийг цогцоор нь ил болгох гэж оруулах саналтай байна. Баярлалаа.

С.Энхтуяа: Манай ажлын гол судас нь компаниуд байгаа. Иймээс компаниудтайгаа холбоотой байх ёстой. Төлөвлөгөөний 1. 1-д зөвхөн тайлагнадаггүй

компаниуд гэж бичсэн байна. Ер нь лиценз эзэмшигч бүх компаниудад танилцуулах хэрэгтэй байна. Мөн нилээд өргөн хүрээг хамарсан, чанартай уулзалтуудыг хийх шаардлагатай байна. Компаниуд зарим нь тайлангаа яаж өгөхөө мэдэхгүй байгаа, иймээс уялдаа холбоотой ажиллах хэрэгтэй. Үр дүн 7.1.2 дээр хийхээр төлөвлөсөн ажлууд нь компаниудтай хийсэн уулзалтаар үр дүн нь гарна гэж бодож байна.

С.Мэндсайхан: Олборлох үйлдвэрлэлтэй холбоотой тоон мэдээлэлүүд янз бүр байна. Үүнийг нэгтгэж нэг болгох санаа орсон байна, харин эдгээр ажлуудыг хэрэгжүүлэхдээ төрийн байгууллагатай ялангуяа статистикийн газартай үйл ажиллагааг уялдуулж зөвлөгөөг авахгүй бол дахиад л зөрүүтэй мэдээлэл гарах эх үүсвэр болно. Татварын ерөнхий газар цахим тайлангаар мэдээлэл авч байгаа, тэдний гол зорилго бол татвараа хэрхэн бүрэн авах вэ гэдэгт байгаа, олборлох үйлдвэрлэл эрхлээгүй компаниуд ч орсон байгаа. Үүнийг тодруулах нь зүйтэй байх. Аж ахуйн нэгжүүд татварын тайлан өгч байхад дахиад л ОҮИТБС-ын тайлан гаргана гээд үндсэн тайлангийн бараг 70,80 хувийг дахиад л давтан өгөх нь аж ахуйн нэгждээ хүндрэлтэй юм. Иймээс үндсэн тайлантай нь уялдуулж явах нь зүйтэй байх, баахан хөрөнгө үр дүнгүй болж магадгүй. ЗГХЭГ дээр Ухаалаг засаглал гэж төрийн мэдээллийн давхацлыг арилгах, тайлагнагч иргэн аж ахуйн нэгжийн ачааллыг бууруулах гэсэн төсөл хэрэгжиж байгаа. Цахим тайлангийн төслийн таницуулга байвал бид танилцаж, саналаа өгөх хүсэлтэй байна.

Ц.Даваацэдэв: Бид бий болчихсон юмны хажуугаар шинэ юм оруулах гээд зовоод байгаа юм. Төлөвлөгөөний 10 –т хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ гэсэн байна. Тайлангийн маягтын загварыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран боловсруулах ажлын хэсэг байгуулж ажиллах саналтай байна, үүнийг төлөвлөгөөнд тусгамаар байна.

Н.Баярсайхан: Компаниуд харьцангуй тайлагнаж сурч байгаа. 2013 онд тайлан гаргасан компанийн тоо буурсан нь үйл ажиллагаа явуулаагүй компаниуд ч бий түүнчлэн цахимаар тайлан авах болсонтой холбоотой байх. Бид цахим тайланг яаж гаргах талаар хэлж өгөөгүй учраас жижиг дунд компаниуд тайлангаа өгөөгүй, аж ахуйн нэгжүүд байнгын нягтлан бодогчгүй байдаг гэх мэт шалтгаанууд байгаа үүнийг бид олж илрүүлэх ёстой. Өөрийн үнэлгээ хийнэ гэдэг дээр компаниуд яагаад тайлангаа өгөхгүй байна гэдэг шалтгааныг тогтоогоод зөв арга хэмжээ боловсруулж ажиллах нь зүйтэй, нэгэнт ил тод болж байгаа зүйлээсээ ухрах шаардлага байхгүй. Одоо уул уурхайг эрэгээр хардаг болсон, компаниудын хөрөнгө оруулалт сайжирч, нийгмийн итгэлцэл нэмэгдэж байгаа. Хууль байхгүй биш байгаа, Газрын тосны тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүд бүгд тайлан гаргах үүрэг байгаа. Иймээс бид ухралт хийсэн мэдээллийг өгч болохгүй байх, тодорхой ололт, амжилт байгаа.

С.Мэндсайхан: Энд ухралт байхгүй, сүүлийн жилүүдэд компанийн өгсөн мэдээлэл үнэн зөв, зөрүү багатай болсон. Зөвхөн нэг тоог олон газар давхцаж өгөхгүйгээр нэгтгэж оруулаад татвар нь татвараа, ОҮИБТС нь тайлангаа гэх мэтээр татаад авах байдлаар төрийн байгууллагууд хоорондоо уялдах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл нэг эх үүсвэрээс авах нь зүйтэй гэсэн санаа юм.

Б.Баярмаа: Компаниуд дотор хайрга дайрга, барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо гэсэн байгууллага байдаг юм байна. Үүний даргыг нь Үндэсний зөвлөл ажлын хэсэг оруулах боломж байна уу? 2016 онд энэ байгууллагыг үйл ажиллагаандаа оролцуулж, сургалтанд хамруулахад санаачилга гарган ажиллахыг ажлын албанаас хүсье.

Б.Дэлгэрмаа: Мэргэжлийн холбоо гэдэгт бүх холбоо орж байгаа.

Б.Баярмаа: Тэр нь УУҮА-д холбогдохгүй тусдаа бие даасан холбоо байна лээ.

Ш.Цолмон: Засгийн газрын 222 тогтоолоор Уул уурхайн үндэсний ассоциаци төлөөллийг томилох эрхтэй.

Н.Алгаа: Одоо тус тусдаа холбоо байгуулагдаад байна. Тухайлбал, Жонш олборлогчдын холбоо, Алт үйлдвэрлэгчдийн холбоо, Төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбоо шинээр байгуулагдсан. Энэ зах зээл, татварын бодлого зэрэг шалтгаанаас өөр өөрийн шийдвэрлэх асуудал байгаа учраас тусдаа холбоод байгуулагдаж байна. Иймээс манайхтай харьцдаг холбоог бид оруулж болно харин хайрга дайргыг хэлж мэдэхгүй байна.

Б.Дэлгэрмаа: Хайрга дайргын холбоо нь нийслэлийн дэд зөвлөлийн гишүүн, Налайх болон Хан-уулын дэд зөвлөлд ороод ажиллахад болох байх.

Н.Алгаа: Бид үүнийг ярилцаж, судлаад боломжтой хэлбэрээр шийдье. Мөн дэд зөвлөлийн ажил дээр 20 сая төгрөг тавиад УУҮА гэсэн байна. Үүнийг бид ИНБ-тай хамтран хийх саналтай байна. Ер нь дэд зөвлөл, суртчилгаан дээрээ болж өгвөл төсөв мөнгийг нь ахиухан тавих хэрэгтэй байна.

Гарсан шийдвэр:

Монголын ОҮИТБС- ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан саналыг тусган зарчимын хувьд батлав.

4. **ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монгол Улсын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн журамд оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай**

Г.Уранцоож: ОҮИТБС-ын нэгтгэл тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах шаардлага байна гэж үзээд ТАН эвслийн гишүүн байгууллага Хүний эрх хөгжил төв, Зориг сангаар зөвлөмжийн хэрэгжилтэд мониторинг хийлгэсэн. Үүнээс зөвлөмжийн хэрэгжилт 20 хувьтай л байна, энэ нь хоёр шалтгаантай гэж үзсэн. Нэгдүгээрт, Үндэсний нэгтгэл тайланг бэлтгэх, хэлэлцүүлэх, батлах үе шат бүрт зөвлөмжтэй яаж ажиллах, хэрхэн хандах нь тодорхой бус байна. Хоёрдугаарт, ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд нь зөвлөмжийг хэрэгжүүлэхэд ямар эрх үүрэгтэйгээр оролцох нь тодорхойгүй байна гэсэн дүгнэлт гаргасан. Иймд холбогдох дүрэм журамд Зөвлөмжийн тухай тодорхой заалт оруулах шаардлагатай гэж үзээд ажлын хэсэг байгуулагдан тодорхой санал боловсруулсан. Өнөөдрийн хурлаас 2013 оны тайлангийн зөвлөмж бүрээр шийдвэр гарч байгаад талархаж байна. Үндэсний зөвлөлийн ажиллах журамд дараах өөрчлөлтийг оруулах санал гаргасан. Үүнд, Үндэсний зөвлөлийн хуралдааныг жилд “2-оос доошгүй” удаа хуралдуулах, Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалд, дүрмийн 17.2-т ... оны тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх шийдвэр болон өмнөх оны тайлангийн зөвлөмжийн хэрэгжилт, Ажлын хэсгийн ажиллах дүрмийн 10.7-д “зөвлөмжийн хэрэгжилт” нэмж оруулах 29.3-т “...тайлангаар өгөгдсөн зөвлөмж, хэрэгжүүлэх санал, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт” нэмж оруулах, Ажлын албаны дүрэмд зөвлөмжийг хэрэгжүүлэх шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана” гэсэн заалтыг тус тус нэмж оруулахаар боловсруулсан байна.

Н.Энхбаяр: Танилцуулгатай холбоотой санал байна уу?

Н.Баярсайхан: Үндэсний зөвлөлийн хуралдааныг жилдээ 2 удаа, шаардлагатай бол тухайн үед нь хуралдаж байх хэрэгтэй байгаа. Үндэсний зөвлөлийн хуралдаанд Ерөнхий сайд өөрөө оролцдог байх, хуралдааныг чанаржуулах, хэлэлцэх асуудлыг өргөжүүлэх, хэлэлцэх асуудлыг хязгаарлахгүй байх шаардлага байна.

Г.Чагнаадорж: Уранцоожийн танилцуулсан Үндэсний зөвлөлийн хурлын шийдвэрт орох саналыг зарчмын хувьд дэмжиж байна. Урьд нь Үндэсний зөвлөлийн хуралд сайд дарга нар их оролцдог байсан, одоо бараг үзэгдэхгүй билэгдлийн чанартай болж байна. Өнөөдөр Статистикийн хорооны дарга байна, хэдийгээр бид энд олон юм яриад, шийдвэр гарсан ч Их хурлын гишүүд, дарга нар хэзээ ч уншихгүй. Үндэсний зөвлөл тааруу ажиллаж байна, бараг ажлын албанаас хоцорч байна.

Н.Алгаа: Үндэсний зөвлөлийн журмыг бүхэлд нь харах хэрэгтэй гэж бодож байна. Үүнд ажлын хэсэг гаргаад ажиллах хэрэгтэй, бид 8 жил ажилласан туршлага байна. Энд өндөр албан тушаалтан сууснаар улам билэгдлийн болно харин сайн ажилладаг, гурван талын төлөөлөл хурлаа ээлжилж удирддаг байдлаар журамд өөрчлөлт оруулах санал байна.

Б.Баярмаа: Үндэсний зөвлөлийн хурал, ажлын хэсгийн хурал ялгарахгүй байна. Бид нэг юмаа хоёр удаа сонсоод байна, өнөөдөр Төрийн ордонд хуралдаж байгаагаараа Үндэсний зөвлөлийн хуралд болоод байна уу? Ажлын хэсгийн хурал дээр Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, дэд зөвлөлийн хийх ажил, эрх үүргийг ялгах, дүрэм журмаа боловсронгуй болгох ажлын хэсэг гаргаад ажиллах санал гаргасан. Үүнийг энэ томъёоллоор нь суугаагүй учраас хүмүүс дахин хэлээд байна, тэр томъёоллоор нь оруулах саналтай байна.

Ц.Даваацэдэв: Дээрх хэлсэн санал нь төлөвлөгөөний 10.5-д тусгагдсан учир дөрөвдүгээр асуудлаа тусад санал хураах нь зүйтэй.

Шийдвэр: Гишүүд 100 хувь дэмжсэнээр батлав.

5. **ХЭЛЭЛЦСЭН НЬ: ОҮИТБС-ын орон нутгийн дэд зөвлөлийн тогтвортой, үр дүнтэй үйл ажиллагааг хангахад тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх арга зам**

Н.Баярсайхан: Бид аймаг суманд дэд зөвлөл байх хэрэгтэй юу, ямар ажлуудыг хийх вэ? Санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх ямар арга зам боломж байна гэдэг талаар судалсан. 2015 оны 12 сарын 8-ны өдөр хуралдсан Ажлын хэсгийн хурлаар дэд ажлын хэсэг байгуулагдсан. Үүнд, сангийн яамны мэргэжилтэн Г.Зулай, Энержи ресурс компанийн Сугармаа, ажлын албаны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа болон миний бие томилогдож ажилласан.

Засгийн газрын 222-р тогтоолоор аймаг, нийслэлд дэд зөвлөлийг байгуулах үүргийг өгсөн. Харин суманд дэд зөвлөл байгуулах шийдвэр байхгүй, дэд зөвлөл хэрхэн ажиллах, юу хийх талаар дүрэм, журам одоогоор гаргаагүй байна. Дэд зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг боловсруулан үүний дагуу дэд зөвлөлийг чадавхижуулахаар ажиллаж байна. Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулийн төсөл УИХ-д өргөн баригдсан, батлагдах шатандаа явж байгаа. Гэвч тус хуулинд дэд зөвлөлийн талаар ямар нэгэн зохицуулалт, заалт ороогүй байгаа. Дэд зөвлөлийн

Засаг даргын захиарамжаар байгуулах уу, ИТХ-ын тогтоолоор байгуулах уу гэдэг нь маргаантай байна. Дийлэнх газар ИТХ-ын тогтоолоор дэд зөвлөлийг байгуулсан байгаа. Засаг дарга газар ашиглах, ус ашиглах зэрэг тодорхой зөвшөөрлийг өгдөг, хяналт тавих чиг үүрэгтэй учраас Засаг дарга өөрөө дэд зөвлөлөө удирдах нь зохимжгүй юм. Иймээс ИТХ-ын тогтоолоор байгуулсан нь зөв байх. Сум дүүрэгт дэд зөвлөл байх зайлшгүй шалтгаан байна. Дэд зөвлөл нь орон нутаг болон компанид аль алинд нь ашигтай. Тухайлбал, уул уурхайн төсөл орон нутгийн засаг захиргааны сум, багийн түвшинд явагддаг. Энэ нь төслийн сөрөг нөлөөлөл шууд орон нутгийн анхан шатны засаг захиргаанд мэдрэгддэг. Иймээс иргэд уул уурхай хэрэггүй, өгөөжгүй, хүний эрх зөрчигдөж, байгаль орчин сүйтгэж байна гэдэг байдлаар ойлгогддог. Тэгэхээр ард иргэдэд салбарын үр ашиг болон төсөл хэрэгжүүлэгчийг эерэгээр ойлгуулахын тулд орон нутгийн түвшинд санаачилга хүрэх хэрэгтэй байгаа юм. Санаачилгыг орон нутгийн түвшинд хүргэх нутагшуулах шаардлага байна, нэг хоёр өдрийн сургалт семинар хийснээр орон нутагт чадавхи үлдэхгүй, үр ашиггүй байгааг анзаарсан. Бид бараг 10 жил үндэсний хэмжээнд санаачилгыг хэрэгжүүлж байна гэвч уул уурхайтай сум болгонд дэд зөвлөл байгуулагдаж чадаагүй байна. Иймээс дэд зөвлөлийн чиг үүргийг өргөжүүлэх шаардлага гарч байна. Дэд зөвлөлийн үлгэрчилсэн дүрмээр 5 чиг үүргээр ерөнхий зүйлүүдийг гаргаж өгсөн. Санаачилгыг орон нутагт хэрэгжүүлэх таван бэрхшээл байна гэж үзсэн. Үүнд, ОҮИТБС-ын мэдээлэл муу, санаачилгын тайланг орон нутгийн түвшинд ашиглахад хүнд, дэд зөвлөл орон нутгийн түвшинд үр дүнтэй ажиллах нөхцөл боломж муу, дэд зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр байхгүй байна. Дэд зөвлөл нь заавал хэрэгжүүлэх 8 төрлийн үйл ажиллагаа байна, үүнд жилдээ 8-10 сая төгрөгийн санхүүжилт хэрэгтэй гэдгийг дэд ажлын хэсгийн гишүүд тооцож гаргасан. Ингээд 2016 оны ажлын төлөвлөгөөнд дараах саналуудыг оруулах саналын боловсруулсан. Зарим нь орсон байна, ороогүй асуудлыг нэмж оруулахыг хүсэж байна. Түүнчлэн Үндэсний зөвлөлийн хурлын шийдвэрийн төсөлд нэмж оруулах зүйлүүд байна, үүнийг тусгаж өгөхийг хүсье.

Сумын түвшинд байгаа олон бүтцийг нэг зөвлөл болгох шаардлагатай байна. Үүнд Уул уурхайн яам илүү анхаарч ажиллах шаардлагатай байна. Одоо орон нутагт ОҮИТБС-ын олон талт дэд зөвлөл, байгалийн нөөцийн менежментийн олон талт зөвлөл буюу Азийн сан Уул уурхайн яамны хамтран хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд сумдад олон талт зөвлөл байгуулагдан ажиллаж байна мөн адилхан гурван талын бүтэцтэй. Ашигт малтмалын хуулийн 42-р зүйлийн дагуу Олон талт гэрээний загвар боловсруулах хүсэлтийг УУЯ Дэлхийн банкинд тавьсан, улмаар хуулийн фирм уг гэрээний загварыг боловсруулаад ЗГ-аар батлуулах шатандаа явж байна. Тэр гэрээний төсөл дээр олон талын бүтэцтэй гэрээний хороо байгуулна гэж заасан байгаа. Тэгэхээр нэг суманд ийм олон хороог тус тусад нь байгуулах болоод байна, иймд нэгтгээд дэд зөвлөл нь салбарын энэ бүх ажлаа авч явдаг болгомоор байна. Азийн сангийн төсөлтэй дэд зөвлөлийг уялдуулах шаардлагатай байна, энэ саналыг Азийн санд хүсэлт тавьсан, УУЯ санал тавьсан тохиолдолд нэгтгэх боломжтой гэсэн. Мөн Эрдэс баялгийн иж бүрэн санаачилга гэж орон нутагт олон талт зөвлөл байгуулна гэсэн, үүнийг бас уялдуулах хэрэгтэй байна.

Төсвийн тухай хуулиар орлогын тодорхой хувь нь орон нутагт очих болж байгаа. Энэ нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс гадна очих мөнгө юм. Энэ орон нутагт авлига бий болох, мөнгөний буруу зарцуулалт бий болох зэрэг байдал үүсэж болзошгүй байгаа учраас үүнийг олон талт зөвлөл хянах шаардлагатай. Иймээс орлогын тодорхой хувиар орон нутгийн дэд зөвлөлийг санхүүжүүлэх боломж байна, үүнд санаачилгыг авч явдаг УУЯ нилээд санаачилгатай ажиллах шаардлага байна. Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулийн төсөл өргөн баригдсан, гэхдээ өргөн барьсанаас хойш нилээд хугацаа өнгөрлөө, энэ хугацаанд зайлшгүй хуульчлах шаардлагатай асуудлууд гараад байна. Иймээс

хуулийн төсөлд нэмж оруулвал яах ёстой вэ? Үүнийг судалж үзмээр байна. Дэд ажлын хэсэгт ажилласан гишүүддээ талархал илэрхийлье. Баярлалаа.

Н.Энхбаяр: За мэдээлэл хийсэн гишүүндээ баярлалаа. Мэдээлэлтэй холбоотой асуух асуулт байвал асууж болно.

Б.Дэлгэрмаа: Дэд зөвлөлийг тамга, албан бланктай болгохыг төлөвлөгөөнд заавал оруулах шаардлагатай юу?

Н.Баярсайхан: Дэд зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг батлахад, тэр үеийн Ерөнхий сайдын ахлах зөвлөх хэлэхдээ, бид дэд зөвлөлийг бие даасан тамга, албан бланктай болгох зорилго тавьж байгаа гэсэн. Орон нутагт дэд зөвлөлийнхөнтэй уулзахад бид ямар тамга тэмдэг ашиглах вэ? ЗДТГ-ын тамга тэмдэгийг ашиглах уу гэдэг асуудал тавьж байсан. Иймээс 2016 онд хийж чадахгүй байж болно. Харин 2020 он хүртэлх стратегийн төлөвлөгөө боловсруулахдаа үүнийг оруулах боломжтой.

Г.Уранцоож: Дэд зөвлөл өөрөө тамга, албан бланк, данстай байна гэдэг ойлгомжгүй байна. Үндэсний зөвлөл хуулийн этгээд биш, аймаг орон нутагт ЗДТГ хариуцаад, харин дэд зөвлөлийн үйл ажиллагаа өөрийн санхүүтай байх ёстой. Түүнийг нь Тамгын газрын төлөвлөгөө, төсөвтэй болгоод Тамгын газраас нэг хариуцсан ажилтантай байж болохгүй юу? Төрийн байгууллага дахиад нэг өөр тамга тэмдэгтэй байх нь зохимжгүй байх.

Б.Батболд: Дэд зөвлөл нь тамга тэмдэгтэй болоод төсөл хэрэгжүүлэх талаар хэллээ. Тэд санаачилгын ажлаа хийхгүй өөр төсөл хэрэгжүүлээд байвал яах вэ? Тамга тэмдэгтэй болно гэдэг чинь бас нэг дарга гарч ирнэ, дараа нь сонгууль болохоор нөгөө дарга солигдоно. Тэгэхээр үүнийг хасвал яасан юм бэ?

Н.Баярсайхан. Энэ бол зөвхөн миний санал биш, дэд зөвлөлийн гишүүдийн санал юм. Үүнийг дүрмээр зохицуулаад зөвхөн ийм үйл ажиллагааны чиглэлээр төсөл авна гэх мэтээр зохицуулах боломжтой байх, орон нутгаас гарсан санал учраас зайлшгүй танилцуулах шаардлагатай байсан.

Г.Чагнаадорж: Дэд зөвлөл тамга тэмдэгтэй байх нь буруу байх, өмнө нь 29 сав газрын захиргаа байгуулаад төрөөс санхүүжиж байгаа. Төрийн өмчит компаниудын ард төрийн томчууд, улсын их хурлын гишүүд байгаа, иймээс энэ Үндэсний зөвлөлийн хуралд оролцож, мэдээлэл авч байх нь зүйтэй.

Н.Баярсайхан. Дэд зөвлөлийн ажлыг тухайн сумын ЗДТГ-ын төсөвт суулгаж болохгүй юм байна. Төсөв нь цаанаасаа зоогоод өгчихсөн, зориулалтаар нь зарцуулах үүрэгтэй байдаг бусад төсөл хөтөлбөрийг улсын төсвөөс санхүүжүүлэх боломжгүй байдаг. Иймээс уул уурхайн салбараас орж байгаа орлогын тодорхой хувийг өөрийг нь хянах, засаглалыг сайжруулахад зориулах шаардлагатайг судлах хэрэгтэй байна.

Г.Уранцоож: Хууль хэрэгжүүлэх бүтэц гэж үзэх ёстой.

Н.Баярсайхан: Засгийн газрын 222-р тогтоолыг хэрэгжүүлэх зөвлөл гэж ойлгох нь илүү ач холбогдолтой байгаа.

Н.Алгаа: Төлөвлөгөөний 10.5-д Үндэсний зөвлөл, ажлын хэсэг, ажлын алба, дэд зөвлөлийн ажиллах журмыг дэд зөвлөл байгуулан шинэчлэн боловсруулж, Үндэсний зөвлөлийн хуралд оруулах нь зөв байх.

Ш.Цолмон: Хөдөө орон нутагт очиход уул уурхайн яамнаас хүн байна уу гэдэг. Тэгэхээр дэд зөвлөлийг арай өргөтгөөд уул уурхайн мэргэжлийн зөвлөл ч юм уу арай өргөтгөн, санхүүжилтийг шийдэх нь зүгээр байх гэсэн үүднээс дэмжиж байна. Засаг дарга бол улс төрийн ажилтан, нэг өдөр л огцордог тэгээд уул уурхайн ажил хоцордог. Иймээс Уул уурхайн яамтай уялдсан арай өргөн хүрээг хамарсан зөвлөл байвал яасан юм гэсэн саналтай байна.

Н.Баярсайхан: Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компани болгон өөрийн зөвлөлтэй, тэнд ажиллаж байгаа хүмүүс нь адилхан байдаг. Зөвхөн нэр, хаяг нь өөрчлөгддөг, Өмнөговьд гэхэд Оюутолгой, Энержи ресурс компаниуд зөвлөл байгуулан, санхүүжүүлэн ажилллуулж байна. Тэгэхээр дэд зөвлөлийг байгуулж, чадавхижуулаад ажиллавал компани бүр зөвлөл байгуулах шаардлагагүй. Дэд зөвлөлөөр бүх уул уурхайн асуудлыг шийдэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

Н.Долгормаа: Миний бодлоор ажлын хэсэг гаргаад Баярсайхан Цолмон нарын хэлсэн саналыг нийлүүлээд боломжтой бүтцийг боловсруулахаар төлөвлөгөөнд оруулъя.

Б.Батболд: Дэд зөвлөлийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх талаар Засгийн газрын тогтоол гаргуулах ажлыг Уул уурхайн яаманд даалгав гэдгээрээ батлах нь зөв байх.

Н.Баярсайхан: Дэд зөвлөлийг засаг дарга хариуцахаар өөрийн хүмүүсийг иргэдийн төлөөлөлд томилж оруулдаг, бид үлгэрчилсэн дүрмийн дагуу ИТХ-аар иргэдээ сонгож оруулахыг зааварчилж, хэлж байгаа.

Н.Алгаа: Юу ч гэсэн эхлээд шийдвэрээ батлаад, мөнгөтэй болох болохгүйгээ мэдчихье. Сангийн яамны журмаар өгсөн санхүүжилтээ үлдсэнийг нь авчихвал яах вэ? Ер нь компаниуд өөрийн зөвлөлөө орон нутагт зайлшгүй байгуулах ёстой. Олон зөвлөл байгуулах тусмаа иргэдийн оролцоо тэр хэмжээгээр нэмэгдэнэ. Бид дэд зөвлөлийн журмаа сайжруулах, бүрэлдэхүүнд орох төлөөллөө зөв тусгах хэрэгтэй. Муу журамтай байвал муу л байна. Журам шинэчлэх нь маш чухал асуудал юм. Өөрөөр хэлбэл иргэдийн оролцоо төлөөллөө яаж бий болгох талаар заавар зөвлөмжөө өгөх хэрэгтэй, дэд зөвлөл нь ОҮИТБС-ын чиг үүргээр ажилладаг байх ёстой гэж бодож байна.

Л.Төр-Од: Үндэсний зөвлөлтэй харьцуулахад орон нутагт байгуулагдаж байгаа дэд зөвлөл нь гурван талынхаа эрх тэгш төлөөллийг чанарын түвшинд хангах шаардлагатай. Мөн ИТХ-ын төлөөллийг дэд зөвлөлд заавал оруулах нь чухал юм.

Шийдвэрийн төслийг уншиж танилцуулан гишүүд дэмжсэнээр батлав.
Шийдвэр:

ОҮИТБС- ын дэд зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилтийг шийдвэрлэх талаар 2016 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газрын тогтоол гаргуулах ажлыг Уул Уурхайн яаманд даалгав.

Н.Энхбаяр: 2016 оны төлөвлөгөөний талаар асуулт асуух гишүүд гараа өргөнө үү. Асуултыг гурван хүнээр таслая.

Д.Эрдэнэчимэг: Төлөвлөгөөний 10.4.3-т ОҮИТБС-ын төрийн өмчит компаниудын судалгаа хийх гэж байна, энэ яг юуг нь судлана гэсэн үг вэ?

Ш.Цолмон: Стандартын дагуу ОҮИТБС-ыг хэрхэн хэрэгжүүлж байна вэ гэдгийг судлана.

Д.Эрдэнэчимэг: Тэгэх шаардлага байна уу, үүний оронд маягтаа боловсруулаад тайландаа оруулах нь зүйтэй. Нэгэнт урьдчилсан баталгаажуулалтаар дүгнэлт нь гарсан байхад дахин судалгаа хийх шаардлагагүй.

Б.Дэлгэрмаа: Ер нь төрийн өмчит компаниудтай уулзаж, яг юуг ил болгох талаар тайлбарлаж, ойлгуулахгүй бол юу хийхээ мэдэхгүй байснаас алдсан тохиолдол байгаа. Иймээс үүнийг судалгаа хийх биш уулзалт зөвлөгөө, зөвлөмж гаргах гэдэг байдлаар төлөвлөгөөнд оруулъя.

Б.Батболд: Дэд зөвлөлийн гишүүдийн чадавхижуулах гэсэн байна. Сургалтуудын зардлыг харж байхад их зөрүүтэй дүн тавьсан байна. Энэ яагаад ийм байна, юун дээр үндэслэсэн бэ?

Б.Дэлгэрмаа: Бид сүүлийн гурван жилд сургалт, өдөрлөг хийсэн туршлага, зардлын дүн дээр үндэслээд хийсэн. Энэ нь хаана, хэдэн хүн хамруулах гэдгээс шалтгаалан төсөв мөнгө нь адилгүй байгаа. Ер нь ирэх гурван жилийн төсөв нилээд бага байгаа, зардлуудыг нилээд танах шаардлагатай байгаа ч орон нутагт чиглэсэн үйл ажиллагааны зардлыг аль болох хасаагүй боломжоор нь тавьсан.

Б.Батболд: Мэргэжлийн ассоциаци гэж ямар байгууллага байна?

Б.Дэлгэрмаа: Бүх холбоод орж байгаа.

Н.Баярсайхан: Мэргэжлийн холбоод гэдэг дээр ИНБ-ыг нэмээд оруулаарай, хамтарч хийнэ гэж Алгаа хэлсэн.

Н.Баярсайхан: Тайлан гаргах тухай зар суртчилгааг зохион байгуулахад 4 сая төгрөг тавьсан байна. Компаниуд үүргээ хэрэгжүүлэхэд яагаад мөнгө гаргах ёстой юм бэ?

Б.Дэлгэрмаа: Тайлан гаргах тухай зарыг өдөр тутмын сонин болон гар утсаар дамжуулан хүргэж байгаа. Өнгөрсөн жил энэ нь тодорхой үр дүнтэй байгааг харсан.

Н.Баярсайхан: Тийм сайн байсан юм бол яагаад 600-хан компани тайлангаа өгсөн юм. Үүнийг Ашигт малтмалын газраар дамжуулаад хийх боломжтой байх.

Б.Дэлгэрмаа: Ашигт малтмалын газар цаасаар тайлан авдаг байхад албан бичиг явуулаад хүчээр авсан. Харин цахим тайлантай болсноор энэ боломжгүй болсон, тайлан гаргалт 60 хувьтай байгааг хангалттай гэж үзэж байгаа.

Л.Төр-Од: Үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэр дээр байгалийн баялагийн хүрээлэн тодорхой хөрөнгийг санаачилгыг хэрэгжүүлэхэд зориулахаар шийдүүлсэн байгаа үүнийг эх үүсвэрт оруулмаар байна. Дараагийн асуулт, төлөвлөгөөг Үндэсний

зөвлөлийн хурлаар хэлэлцэж, батлаж байна үүнийг хэрэгжүүлэх нь Үндэсний зөвлөл, ажлын алба байгаа байх. Үүнийг зөвхөн ажлын алба биш хамтран ажиллаж байгаа талуудтайгаа гэрээлээд ажиллах боломж байна уу?

Н.Алгаа: Сургалт сурталчилгааг хариуцан хийх байгууллагыг ямар журмаар яаж сонгох вэ? Бид тэр журмаар нь орж болох юм.

Б.Дэлгэрмаа: Бид Дэлхийн банкны хөрөнгийг батласан төсөв, журмын дагуу зарцуулах үүрэгтэй, хэрвээ буруу болон өөр зүйлд зарцуулсан бол эргэж төлөх үүрэг хүлээдэг учраас бүх ажлыг журмын дагуу хийх ёстой. Хөрөнгийг зарцуулалтыг Дэлхийн банкны төлөөлөгчийн газрын санхүү, худалдан авалт хариуцсан мэргэжилтэнгүүд, Бээжингийн оффис, Вашингтоны оффисын зөвлөхүүд байнга ирж шалгадаг, бид тайлагнадаг журамтай.

Л.Долгормаа: Төлөвлөгөөнд энэ тайланг янзлах талаар орсон уу?

Б.Долгормаа: Төлөвлөгөөний 4.2-т зорилтот бүлгүүдэд зориулан хураангуй тайлан, тараах материал хэвлэн нийтлэх гэж оруулсан байгаа. Энэ нь тайланг бүтнээр нь хэвлэхгүй хэсэгчлэн хэвлэнэ.

Н.Алгаа: Би өөр ойлгож байна. Тайланг сайн болгох, хэрэггүй мэдээлэл цуглуулахгүйн тулд тайлангийн маягтуудаа болгох ёстой гэж үзэж байгаа, байнга хэлсээр ирсэн. Үүнийг сайжруулахын тулд маягтаа зөвшилцвөл илүү үр дүнтэй.

Б.Дэлгэрмаа: Таны хэлж байгаа санал төлөвлөгөөний 2.2-т орсон байгаа.

Н.Баярсайхан: Төлөвлөгөөний 2.2-т оруулсан хураангүй тайлан хэвлэх гэдгийг аймаг аймгаар салгаж болох уу?

Б.Дэлгэрмаа: Болно.

Н.Алгаа: Би ойлгосон, энэ том тайлангаас шүүхийг хэлсэн.

Б.Дэлгэрмаа: 2.2-т төлөвлөснөөр хараат бус нэгтгэгчийг сонгоод, эхлэлтийн семинарыг зохион байгуулж, тайлангийн маягт, үзүүлэлт, материаллаг босгыг зөвшилцөх, эцэслэн тохиролцох ажлыг хийх байгаа. Олон талт зөвлөл маань зөвшилцөөд шийдвэр гаргаад явах боломжтой.

Д.Эрдэнэчимэг: Үүнд төрийн өмчит компаниудын маягтыг оруулах боломжтой юу?

Ш.Цолмон: Энэ нь аудиторын маягт юм.

Б.Дэлгэрмаа: ОҮИТБС-ын тайлангийн маягт Үндэсний статистикийн хороогоор батлагддаг. Нэмэлт үндсэн мэдээлэл цуглуулахад ямар мэдээлэл авах вэ гэдгийг олон талт зөвлөлтэй зөвшилцөх нь аудиторын ажил юм.
Шийдвэрлэсэн нь .

Н.Энхбаяр: Шийдвэрийн төсөлд гишүүдийн саналыг тусган батлахаар оруулъя. Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна, идэвхтэй оролцсон гишүүдэд баярлалаа.

Хурал 18,00 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Уул уурхайн яамны СБТГ-ын дарга Н.Энхбаяр

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,
ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн
ажилтан А.Отгонтунгалаг